

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 сарын 14 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.

2 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн хэмжээ, сүлжээ, төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн болон төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээг тогтоохдоо эрх зүйн байдал, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх зарчмыг баримтална.

3 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газар Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг 2020 оны 06 дугаар сард багтаан зохион байгуулна.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР